



МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2021 оны 11 сарын 30 өдөр

Дугаар А - 314

Улаанбаатар хот

Заавар батлах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 22 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, Валютын зохицуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Гадаад валют, тооцооны нэгжээр үнэ тогтоох, төлбөр тооцоо гүйцэтгэх, зарлан сурталчлах зөвшөөрөл олгох үйл ажиллагааны заавар”-ыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2. Энэ тушаалыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газар (А.Энхжин)-т даалгасугай.

3. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитын газар (Т.Амарсайхан)-т даалгасугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ



Б.ЛХАГВАСҮРЭН

**ГАДААД ВАЛЮТ, ТООЦООНЫ НЭГЖЭЭР ҮНЭ ТОГТООХ,
ТӨЛБӨР ТООЦОО ГҮЙЦЭТГЭХ, ЗАРЛАН СУРТАЛЧЛАХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗААВАР**

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэ заавраар Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1-т заасан зөвшөөрлийг Монголбанкнаас олгохтой холбогдох харилцааг зохицууна.

**ХОЁР. ЗӨВШӨӨРӨЛ ШААРДАГДАХГҮЙ ХИЙЖ ГҮЙЦЭТГЭХ ГАДААД
ВАЛЮТЫН ГҮЙЛГЭЭ**

2.1. Дор дурдсан тохиолдолд гадаад валют, тооцооны нэгжээр үнэ тогтоож, төлбөр тооцоо гүйцэтгэж, зарлан сурталчилж болно.

2.1.1. Банкны тухай хуулийн 3.1.1-т заасан банк, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 4.1.1-т заасан үйл ажиллагааг эрхэлж буй банк бус санхүүгийн байгууллагаас эрхэлж байгаа Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.4-т заасан үйл ажиллагаа;

2.1.2. Монголбанкнаас холбогдох хууль тогтоомж, журамтай нийцүүлэн зөвшөөрсөн бусад тохиолдол.

**ГУРАВ. ЗӨВШӨӨРӨЛ ХҮССЭН БАРИМТ БИЧГИЙГ ХҮЛЭЭН АВАХ,
ШИЙДВЭРЛЭХ**

3.1. Иргэн, хуулийн этгээд нь Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1-т заасан зөвшөөрөл авах хүсэлтийг энэ зааврын 2.1-т зааснаас бусад тохиолдолд Монголбанканд ирүүлж болно.

3.2. Монголбанк зөвхөн Монгол Улсын эдийн засгийн харьяат хооронд Монгол улсын нутаг дэвсгэр дээр холбогдох гэрээ, хэлэлцээрийн дагуу хийгдэж буй гадаад валют, тооцооны нэгжээр үнэ тогтоох, төлбөр тооцоо гүйцэтгэх, зарлан сурталчлах зөвшөөрөл хүссэн хүсэлтийг хүлээн авна. Хүсэлтийг холбогдох гэрээ, хэлэлцээрийг байгуулахаас өмнө гэрээнд оролцогч тал тус бүр ирүүлнэ.

3.3. Энэ зааврын 3.1-т заасан хүсэлт гаргагчид тавигдах ерөнхий шаардлага

3.3.1. Иргэний үнэмлэх, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

3.3.2. Гадаад валют, тооцооны нэгжээр үнэ тогтоох, төлбөр тооцоо гүйцэтгэх, зарлан сурталчлах зөвшөөрөл авахыг хүссэн үйл ажиллагааг зохицуулж буй гэрээний хуулбар, монгол хэл дээрх гэрээний албан ёсны орчуулга;

- 3.3.3. Гадаад валют, тооцооны нэгжээр үнэ тогтоох, төлбөр тооцоо гүйцэтгэх, зарлан сурталчлах харилцаанд оролцогчоос зөвшөөрөл шаардсан тохиолдолд зөвшөөрөл шаардаж буй этгээдээс баталгаажуулах албан бичиг;
- 3.3.4. Гадаад валют, тооцооны нэгжээр үнэ тогтоох, төлбөр тооцоо гүйцэтгэх, зарлан сурталчлах үйл ажиллагаа нь олон улсын гэрээгээр зохицуулагдаж буй тохиолдолд холбогдох эрх бүхий байгууллагаас тодорхойлсон албан тоот, албан ёсны орчуулга.
- 3.3.5. Зөвшөөрөл хүссэн албан тоот.
- 3.4. Монголбанк дараах хүчин зүйлсийг харгалзан үзэж хүсэлтийг шийдвэрлэнэ.
- 3.4.1 Үйл ажиллагааны чиглэл нь олон улсын байгууллага, дипломат төлөөлөгчийн газар, эдийн засгийн харьяат бус, олон улсын гэрээний зохицуулалтад хамаарах үйл ажиллагаа эрхэлж буй эсэх;
- 3.4.2 Монгол Улсын аюулгүй байдал болон эдийн засаг, мөнгөний бодлогын зорилтод үзүүлэх үр нөлөө, ач холбогдол;
- 3.4.3 Гадаад валютаар төлбөр тооцоо хийж гүйцэтгэх давтамж;
- 3.4.4 Бусад.
- 3.5. Монголбанк дараах тохиолдолд зөвшөөрөл олгохоос татгалзана.
- 3.5.1 Хүсэлтэд заасан үйл ажиллагаа нь Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.2 болон 4.3-т заасан үйл ажиллагаанд хамаарах тохиолдолд;
- 3.5.2 Монголбанкнаас шаардлагагүй хэмээн үзсэн бусад тохиолдол;
- 3.6. Монголбанкны Мөнгөний захын үйл ажиллагаа хариуцсан газар хүсэлтийг хүлээн авч Монголбанкны Хууль, эрх зүй, Мөнгөний бодлого, Төлбөр тооцоо хариуцсан газар, шаардлагатай тохиолдолд холбогдох яам, хэрэгжүүлэгч агентлагуудын саналыг авсны үндсэн дээр зөвшөөрөл олгох эсэх саналыг Монголбанкны Ерөнхийлөгчид танилцуулж шийдвэрлүүлнэ.
- 3.7. Монголбанк хуулийн этгээдэд зөвшөөрөл олгохдоо хүсэлт гаргагч бүрт эрх тэгш хандах зарчмыг баримтална.
- 3.8. Монголбанк хуулийн этгээдэд зөвшөөрөл олгохдоо уг зөвшөөрлийг хэсэгчлэн, тодорхой хугацаа, нөхцөл заасан байдлаар олгож болно.
- 3.9. Монголбанк зөвшөөрөл хүссэн иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийг хүлээн авсанаас хойш ажлын 15 хоногт багтаан Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1-т заасан зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэж, шийдвэр гарсанаас хойш ажлын 5 хоногийн дотор зөвшөөрөл хүсэгчид мэдэгдэнэ.
- 3.10. Шаардлагатай тохиолдолд хүсэлтэд дурдсан үйл ажиллагаа нь Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн хүрээнд гадаад валютаар гүйцэтгэх боломжтой гүйлгээнд хамаарах эсэх талаар Монголбанкнаас тайлбар хийж болно.
- 3.11. Монголбанк хуулийн этгээдэд зөвшөөрөл олгохоос татгалзсан шалтгаанаа тайлбарлах үүрэг хүлээхгүй.

ДӨРӨВ. ХЯНАЛТ

4.1. Энэхүү зааврын биелэлтэд Мөнгөний захын үйл ажиллагаа хариуцсан газар болон Дотоод аудит хариуцсан газар хяналт тавьж ажиллана.

_____oOo_____

“Гадаад валют, тооцооны нэгжээр үнэ тогтоох, төлбөр тооцоо гүйцэтгэх, зарлан сурталчлах зөвшөөрөл олгох үйл ажиллагааны заавар”-ын нэгдүгээр хавсралт

ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ТУХАЙ

20... оны ... дугаар
сарын-ний өдөр

№

Улаанбаатар хот

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Валютын зохицуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 6, 9 дэх хэсэг, Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийг тус тус үндэслэн гадаад валют, тооцооны нэгжээр үнэ тогтоох, төлбөр тооцоо гүйцэтгэх, зарлан сурталчлах зөвшөөрлийг доорх тусгай нөхцөлтэйгөөр.....
.....(байгууллагын нэр) –д олгож буйг үүгээр мэдэгдэж байна.

Тусгай нөхцөл:

.....
.....
.....

МОНГОЛБАНКНЫ

ЕРӨНХИЙЛӨГЧ